



## “БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь “Компанийн тухай” хууль, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль болон бусад холбогдох хүчин төгөлдөр хууль, эрх бүхий байгууллагаас баталсан журмуудыг мөрдлөг болгоно.

### Хоёр. Эрсдэлийн удирдлагын журмын зорилго

- 2.1 Энэхүү журмыг дараах зорилгоор хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.1.1 Компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, өгөөжийн оновчтой түвшинг хангах тогтолцоог бүрдүүлэх;
  - 2.1.2 Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах үе шатыг тодорхойлох;
  - 2.1.3 Эрсдэлийн удирдлагын тохиромжтой арга хэмжээ, хэрэгслийг ашиглах замаар тухайн үйл ажиллагааны эрсдэлийг зөвшөөрөгдсөн түвшинд хадгалах;

### Гурав. Эрсдэлийн удирдлагын зарчим

- 3.1 Компани бизнесийн үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд, эрсдэлийг зохистой түвшинд удирдан, ёс зүйтэй, шударга байдлаар явуулах;
- 3.2 Компани хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, бизнесийн зорилгодоо хүрэх;
- 3.3 Компанийн ажилтан бүр өөрийн хариуцсан үйл ажиллагааны эрсдэлийн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэгч байх;
- 3.4 Компанийн бүх ажилтны хамтын оролцоотойгоор эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, мэдээллийг тогтмол сайжруулах замаар компанийн эрсдэлийн соёлыг хэвшүүлж ажиллах;
- 3.5 Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үндсэн болон баримт бичгийн хүрээнд алба, нэгжүүд өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу эрсдэлийг үр дүнтэй, зохистой түвшинд удирдах зохицуулалтыг холбогдох журам, зааварт тусган хэрэгжүүлэх;
- 3.6 Хүлээн зөвшөөрөх эрсдэл нь тоон болон чанарын тодорхой шалгуур үзүүлэлт, үндсэн зарчмууд дээр үндэслэн, уялдаа холбоотой тодорхойлогддог байх;



## Дөрөв. Эрсдэлийн удирдлагын хамрах хүрээ

- 4.1 Компанийн үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогоос хамааруулан эрсдэлийг дараах байдлаар ангилна. Үүнд:
- 4.1.1 **Системийн эрсдэл:** Улс төр, зохицуулалтын орчин, эрх зүй, макро эдийн засаг, зах зээл болон татвар, ханшийн өөрчлөлт зэрэг гадаад орчны хүчин зүйлсээс шалтгаалан компани санхүүгийн алдагдал хүлээх, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг ойлгоно.
  - 4.1.2 **Үйл ажиллагааны эрсдэл:** Бизнесийн нэр хүнд, хүний нөөц, техник програм хангамж, санхүүгийн үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн үл нийцэл нийцэл зэргээс хамаарч компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа алдагдахыг ойлгоно.
  - 4.1.3 **Харилцагчийн эрсдэл:** Харилцагчийг таних, арилжаа хийж буй мөнгөн хөрөнгийн эх үүсвэр, хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох, баримтжуулах үйл ажиллагаанаас хамаарч компанийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, бусад эрсдэл тохиолдохыг ойлгоно.

## Тав. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үе шат

- 5.1 Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа дараах үе шаттай байна:
- 5.1.1 Эрсдэлийг илрүүлэх буюу урьдчилан тодорхойлох;
  - 5.1.2 Эрсдэлийг үнэлэх буюу компанийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам, эрсдэлийн дүгнэлт боловсруулах үнэлгээний аргачлал болон бусад холбогдох баримт бичигт нийцүүлэн тохиолдож болох эрсдэлийг тооцоолох;
  - 5.1.3 Эрсдэлийн үнэлгээний дагуу тохирсон арга хэмжээг авах;
  - 5.1.4 Эрсдэлийг хянах үйл ажиллагааны хүрээнд эрсдэлд тохирсон арга хэмжээ авсан аливаа шийдвэрийн хэрэгжилтийг хянах үйл ажиллагаа;
  - 5.1.5 Компанийн эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллэр хангах, тайлагнах;

## Зургаа. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт

- 6.1 Өдөр тутмын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дотоод бодлого, дүрэм, журам, зааврын хүрээнд гүйцэтгэх, хянах, заавар зөвлөмжөөр хангах зэрэг тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэх цогц харилцааг ойлгоно.
- 6.2 Өдөр тутмын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх этгээдийн чиг үүргийн хуваарь нь дараах хүрээг хамаарна. Үүнд:
  - 6.2.1 **Төлөөлөн Удирдах Зөвлөл** – Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, журам, аргачлал, тогтолцоог батлах, өөрчлөлт оруулах
  - 6.2.2 **ТУЗ-н дэргэдэх Аудитын хороо** – Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон ТУЗ-ийн даргаас өгсөн удирдамж, чиглэлийн хүрээнд компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалт хийх, тайлагнах
  - 6.2.3 **Гүйцэтгэх захирал** – Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэвийн үйл ажиллагааг хангах, холбогдох ажилтныг шаардлагатай удирдамжаар хангах, холбогдох шийдвэрийг гаргаж мөрдүүлэх, компанийн нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, шаардлагатай тохиолдолд холбогдох мэдээллийг ТУЗ-д тайлагнаж, шийдвэрлүүлэх.
  - 6.2.4 **Албадын удирдлага болон салбарын эрхлэгч** – Удирдаж буй салбар болон алба нэгжийн үйл ажиллагааг хянах, үүсч болзошгүй эрсдэлийг тооцоолох,



удирдах, зохистой арга хэмжээг авах талаар санал боловсруулж, удирдлагыг мэдээллээр хангах

- 6.2.5 **Мэргэжилтнүүд** – Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, эрсдэл учирсан, эсвэл учирч болзошгүй тохиолдолд хариуцсан эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх, холбогдох арга хэмжээ авах талаар санал боловсруулах

#### **Долоо. Эрсдэлийг удирдах үе шат**

- 7.1 Компанийн мэргэжилтэн бүр өөрийн ажлын чиг үүрэгт хамаарах асуудлаар үүссэн болон үүсч болзошгүй эрсдэлийн талаар хяналт тавьж ажиллана.
- 7.2 Өндөр эрсдэл учирч болохуйц, их хэмжээний хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд яаралтай мэдэгдэнэ.
- 7.3 Мэргэжилтэн нь өөрийн ажлын чиг үүрэгтэй уялдуулан гадаад болон дотоод зах зээл, эдийн засаг, эрх зүй, харилцагчийн талаарх судалгаага тогтмол хийж, эрсдэлийг урьдчилан илрүүлэх талаар санаачлага гаргаж ажиллана.
- 7.4 Эрсдэл үүсч болохуйц нөхцөл бүрдэх, үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдах, их хэмжээний хохирол үүсэх болон бусад тохиолдож болохуйц сөрөг нөлөөг илрүүлж, холбогдох албан тушаалтанд мэдээлнэ.

#### **Найм. Эрсдэлийг үнэлэх, хянах**

- 8.1 Эрсдэлийг үүсэх магадлал болон түүнээс үүсэх хохирлын хэмжээгээр үнэлнэ.
- 8.2 Харилцагчийн эрсдэлийг үнэлэхдээ энэхүү журмын Хавсралт 1-д тусгасан үнэлгээний матрицын дагуу үнэлж, тохирох арга хэмжээг авна.
- 8.3 Шаардлагатай тохиолдолд зөвшөөрөгдсөн эрсдэлийн түвшинд компанийн өдөр тутмын үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэхгүйгээр тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

#### **Ес. Хариуцлага**

- 9.1 Энэхүү журмыг зөрчсөн мэргэжилтэн, албан тушаалтанд компанийн “Ёс зүйн дүрэм”, дотоод журам болон холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт тусгасан хариуцлага хүлээлгэнэ.

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн “Үйл ажиллагааны  
эрсдэлийн удирдлагын журам”-ын Хавсралт-1

**Харилцагчийн эрсдэлийн үнэлгээний матриц**

Эрсдэлтэй харилцагч, эрсдэлтэй үйл ажиллагааг тодорхойлох үйл ажиллагааг доорх эрсдэлийн матрицад тулгуурлан хийнэ. Матрицын үнэлгээг 1-10 оноогоор үнэлэх ба үнэлгээнээс хамааран нарийвчилсан хяналтыг хийж гүйцэтгэнэ.

Эрсдэлийн үнэлгээний матриц		Эрсдэлтэй үйл ажиллагаа		
		Сүүлийн 6 сарын хугацаанд үнэт цаас худалдан авах зорилгоор 10 сая төгрөг болон түүнээс дээш дүнтэй 2 ба түүнээс дээш давтамжтай гүйлгээ	20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ	Өмнөх жилийн ХЗЗ-н арилжааны нийт үнийн дүнгийн 30%-иас дээш дүнтэй гүйлгээ
Харилцагчийн эрсдэлийн хүчин зүйлс	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулсан	1	2	5
	Хөрөнгө, орлогын эх үүсвэр тодорхойгүй	1	3	5
	Насанд хүрээгүй этгээд	1	3	5
	Оршин суугаа/байгаа газар тодорхойгүй	2	4	7
	Баримт бичгийн зөрчилтэй	3	6	8
	Улс төрд нөлөө бүхий этгээд	5	7	10
	Харилцагч нь ойлгоход төвөгтэй өмчлөлийн хэлбэртэй хуулийн этгээд	1	3	5
	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл тодорхойгүй	1	3	5



	МУТС-тэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд	6	7	10
Газар зүйн байршил, бүс нутгийн эрсдэлийн хүчин зүйлс	ОУ-ын байгууллагаас МУТС-тэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын иргэн, хуулийн этгээд	6	7	10
	Санхүүгийн хориг арга хэмжээ, хязгаарлалат болон ижил төстэй арга хэмжээнд орсон улсын иргэн, хуулийн этгээд	6	7	10
	Найдвартай эх сурвалжаас авлига хээл хахууль болон бусад гэмт хэргийн үзүүлэлт өндөртэй гэж тодорхойлогдсон улсын иргэн, хуулийн этгээд	2	4	7
Бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагчид хүргэх хэлбэрээс хамаарах хүчин зүйлс	Өөрийн биеэр ирэлгүй хийсэн гүйлгээ, арилжаа /Онлайн брокер үйлчилгээ/	1	3	5
	Номинал дансаар дамжуулан төлбөр тооцоо гүйцэтгэх	1	3	5

Дээрх эрсдэлийн үнэлгээний матрицын дагуу үнэлэгдсэн онооноос хамааран дараах нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.



**1-5 оноо:**

1. Компани нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, хянах
2. Тухайн харилцагчаас эрхэлж буй ажил, бизнесийн болон хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой шаардлагатай мэдээллийг шинэчлэх, нэмэлтээр гаргуулж авах
3. Харилцагчийн данс, гүйлгээнд хяналт тавих давтамжийг нэмэгдүүлэх

**6-15 оноо:**

1. Компани нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, хянах
2. Тухайн харилцагчаас эрхэлж буй ажил, бизнесийн болон хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой шаардлагатай мэдээллийг шинэчлэх, нэмэлтээр гаргуулж авах
3. Харилцагчийн данс, гүйлгээнд хяналт тавих давтамжийг нэмэгдүүлэх
4. Харилцагчийг нарийвчлан мэдэх үйл ажиллагааны хүрээнд дэлгэрэнгүй “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
5. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан гүйлгээ хийсэн бол итгэмжлэгдсэн төлөөлөгч болон итгэмжлэгчээр нарийвчилсан “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
6. Харилцагчийн дансанд хийгдэж байгаа гүйлгээг сэжигтэй гэж үзэх үндэслэлтэй бол мээдэлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтанд мэдэгдэж, батлагдсан маягтын дагуу Монгол Банкны СМА-нд мэдээлнэ.

**16 болон түүнээс дээш оноо:**

1. Компани нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, хянах
2. Тухайн харилцагчаас эрхэлж буй ажил, бизнесийн болон хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах
3. Харилцагчийн данс, гүйлгээнд хяналт тавих давтамжийг нэмэгдүүлэх
4. Харилцагчийг нарийвчлан мэдэх үйл ажиллагааны хүрээнд дэлгэрэнгүй “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
5. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан гүйлгээ хийсэн бол итгэмжлэгдсэн төлөөлөгч болон итгэмжлэгчээр нарийвчилсан “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
6. Харилцагчийн дансанд хийгдэж байгаа гүйлгээг сэжигтэй гэж үзэх үндэслэлтэй бол мээдэлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтанд мэдэгдэж, батлагдсан маягтын дагуу Монгол Банкны СМА-нд мэдээлнэ.
7. Тухайн харилцагчтай бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг авна. Энэ зөвшөөрөл нь энэхүү хөтөлбөрийн хүрээнд явагдах бөгөөд компанийн хүлээн зөвшөөрөх хэмжээнээс өндөр МУТС эрсдэл бүхий харилцагч болон үнэн зөв мэдээллийг өгөхөөс зайлсхийсэн харилцагчтай бизнесийн харилцаа үүсгэхээс татгалзах эрхтэй.